Дуусаагүй барилга байгууламж	5,800.0	5,800.0	0.0	0.2
Номын фонд			0.0	0.0
Бусад үндсэн хөрөнгө	240,876.3	236,736.4	-4,139.9	8.3
БИЕТ БУС ХӨРӨНГӨ	129,258.0	129,052.0	-206.0	4.5
Программ хангамж	780.0	780.0	0.0	0.0
Бусад биет бус хөрөнгө	128,478.0	128,272.0	-206.0	4.5
НИЙТ ДҮН	2,591,385.0	2,838,831.0	247,446.0	100.0

Эх сурвалж: Баян-Овоо сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн үлдэгдэлд 99.8 хувь ЗДТГ, 1.2 хувь нь ИТХ-ийн хөрөнгө байна.

Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	25,025.5	35,115.2	10,089.7	1.2
ЗДТГ	2,566,359.6	2,803,715.8	237,356.2	98.8

НИЙТ ДҮН	2,591,385.1	2,838,831.0	247,445.9	100.0
-----------------	--------------------	--------------------	------------------	--------------

Эх сурвалж: Баян-Овоо сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 1,208,437.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 198,329.7 мянган төгрөгийн төсвийн хөрөнгөөр худалдан авч 227,741.6 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан ба 178,625.4 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хассан байна.

Хүснэгт 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	426,071.3	Хасагдсан	178,625.40
Худалдан авсан	198,329.7	Худалдсан	69,382.7
Хандиваар		Акталсан	47,999.70
Шилжүүлэн авсан	193,120.8	Шилжүүлсэн	1,243.0
бусад	34,620.8	бүтэц өөрчлөлт	60,000.0

Эх сурвалж: Баян-Овоо сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 80,143.6 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 123,089.2 мянган төгрөг болж 42,945.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН	80,143.6	123,089.2	42,945.6	100.0
Ажилчидтай холбогдсон өглөг		542.8	542.8	0.4
Бараа үйлчилгээний зардлын өглөг	360.0	6,527.2	6,167.2	5.3
Байгууллагад төлөх өглөг	79,101.9	116,019.2	36,917.3	94.3
Хувь хүмүүст өгөх өглөг	681.7		(681.7)	-
Дүн	80,143.6	123,089.2	42,945.6	100.0

Эх сурвалж: Баян-Овоо сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөр нь 123,089.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд 116,019.2 мянган төгрөг нь ОНХС, 542.8 мянган төгрөг нь ЗДТГ, 6,527.2 мянган төгрөг нь цэцэрлэгийн тогтмол зардлын өглөгийн үлдэгдэл байна.

Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	3,311.7		(3,311.7)	-
ЗДТГ	360.0	542.8	182.8	0.4
ОНХС	79,391.9	116,019.2	36,627.3	94.3
Цэцэрлэг		6,527.2	6,527.2	5.3
ДҮН	83,063.6	123,089.2	40,025.6	100.0

Эх сурвалж: Баян-Овоо сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 2,525,479.0 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 2,582,266.3 мянган төгрөг болж, 56,787.3 мянган төгрөгөөр төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 12. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	530,810.8	530,810.8	-	20.6
Өмч: - төрийн			-	-
Хуримтлагдсан үр дүн	1,694,822.0	1,779,318.5	84,496.5	68.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	299,846.2	272,137.0	(27,709.2)	10.5
Дүн	2,525,479.0	2,582,266.3	56,787.3	100.0

Эх сурвалж: Баян-Овоо сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 56,787.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.7 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2022.12.19-ний өдрийн хуралдаанаар 08/01 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 2,758,399.0 мянга, хүү торгуулийн орлогыг 20,000.0 мянга, нийт 2,778,399.0 мянган төгрөгөөр баталсан ба сумын ИТХ-ын 2023.07.25-ний өдрийн 11/03 дугаар тогтоолоор 271,885.2 мянган төгрөгийн орлогыг нэмж тодотгосон байна.

Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	2,580,799.0	2,372,453.8	(208,345.2)	91.9
ЦХТА рлого /суутган/	1,259,140.0	1,287,551.6	28,411.6	102.3
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	34,400.0	25,672.4	(8,727.6)	74.6
Бууны татвар	855.0	1,035.0	180.0	121.1
ИОТХ	24,000.0	23,714.2	(285.8)	98.8
Улсын тэмдэгтийн хураамж	1,500.0	1,508.0	8.0	100.5
Хадгаламжийн хүүгийн орлого	6,900.0	8,064.5	1,164.5	116.9
Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсаны орлого	3,000.0	6,066.1	3,066.1	202.2
Малд ногдуулах албан татвар	228,444.0	158,224.0	(70,220.0)	69.3
Газрын төлбөр	48,260.0	28,110.0	(20,150.0)	58.2
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	13,700.0	12,188.0	(1,512.0)	89.0
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	948,600.0	814,320.0	(134,280.0)	85.8
ТТАМАТөлбөр	12,000.0	6,000.0	(6,000.0)	50.0
Бусад татвар			-	
2.Татварын бус орлого	28,200.0	28,466.5	8,466.5	142.3
2.1.Хүү торгуулийн орлого	20,000.0	28,466.5	8,466.5	142.3
2.2 Дуудлага худалдаа	7,200.0			
2.3.төсөвт байгууллагын өөрийн орлого	1,000.0	1,000.0		
Нийт дүн	2,608,999.0	2,400,920.3	(199,878.7)	92.0

Эх сурвалж: Баян-Овоо сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 92 хувь буюу 199,878.7 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 28,411.6 мянга, бууны татвар 180.0 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 1,164.5 мянга, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого 3,066.1 мянга, хүү торгуулийн орлого 8,466.5 төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Харин үл хөдлөх хөрөнгийн албан татвар 8,727.6 мянга, газрын төлбөр 20,149.9 мянга, ан агнуурын орлого 134,280.0 мянга, хог хаягдлын үйлчилгээний төлбөр 1,512.0 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмалын албан татвар 6,000.0 мянга, газрын дуудлага худалдааны орлого 7,200.0 мянга, малд ногдуулах албан татвар 70,220.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна

Төсөвт байгууллагын өөрийн орлогод сумын Засаг даргын Тамгын газар 1,000.0 мянган төгрөгийн орлогыг оруулахаар төлөвлөж 1,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна.

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 68,623.3 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 76,709.4 мянга, Орон нутгийн хөгжлийн сан 179,000.0 мянган төгрөгийн орлого оруулахаар төлөвлөж 202,373.0 мянган төгрөг төвлөрсөн байна.

3.8 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 2,956,421.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж 2,696,835.4 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 1,471,967.6 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулж 1,224,867.8 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

Хүснэгт №14. Төсвийн гүйцэтгэл /мянган төгрөг/

Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Нийт зарлага ба зээлийн дүн	2,956,421.0	2,696,835.4	257,240.5	91.2
70105 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	158,191.500	141,943.5	13,938.142	89.7
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	148,932.300	134,994.2	13,938.1	100.0
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	200.000	200.0	0.0	100.0
80825 Багийн ИНХ-ын даргын урамшуулал	9,059.200	6,749.3	2,309.9	74.5
70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	993,578.1	985,987.0	7,555.900	99.2
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	591,188.7	588,050.8	3,137.9	99.5
80106 Баг хорооны үйл ажиллагааны зардал	97,794.2	97,103.5	690.7	99.3
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	1,000.0	800.0	200.0	80.0
82310 Гамшгаас сэргийлэх сургалт	17,000.0	17,000.0	0.0	100.0
81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	85,000.0	81,512.7	3,487.3	95.9
82212 хур хог хаягдал, орчны бохирдол	13,460.0	13,420.0	40.0	99.7
81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал	188,135.2	188,100.0	35.2	100.0
70503 Орон нутгийн зорилтот орон оруулалт	1,352,402.1	1,224,867.8	127,534.3	90.6
80904 Нийгмийн зориулалттай барилга	729,708.3	661,355.4	68,352.9	90.6
83401 ОНХС-Итгэлцүүрээр тооцох	145,343.2	152,812.0	-7,468.8	105.1
83402 ОНХС-хайгуулийн тусгай зөвшөөрлийн төлбөр	38,740.0	25,760.8	12,979.2	66.5
83403-ОНХС - Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	31,166.6	31,166.6	0.0	100.0

83405 ОНХС Малын тоо толгойн албан татвар	228,444.0	151,400.0	77,044.0	66.3
83406 ОНХС -бусад	179,000.0	202,373.0	-23,373.0	113.1
71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	43,998.4	43,828.5	169.9	99.6
80112 Нийтлэг үйлчилгээ	43,998.4	43,828.5	169.9	99.6
71702 Соёл урлаг	60,757.1	40,393.7	20,363.4	66.5
80112 Нийтлэг үйлчилгээ	60,757.1	40,393.7	20,363.4	66.5
71801 Сургуулийн өмнөх боловсрол	84,517.9	84,517.9	0.0	100.0
80112 Нийтлэг үйлчилгээ	84,517.9	84,517.9	0.0	100.0
71802 Ерөнхий боловсрол	180,461.2	175,197.1	5,264.1	97.1
80112 Нийтлэг үйлчилгээ	180,461.2	175,197.1	5,264.1	97.1
72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	82,514.7	100.0	82,414.7	0.1
82611 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	82,514.7	100.0	28,935.6	84.2

Эх сурвалж: Баян-Овоо сумын Засаг даргын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.9.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн бөгөөд сумын ИТХ-ын 2022.12.19-ний өдрийн хуралдаанаар 08/01 дугаар тогтоолоор нийт орлогыг 3,569,106.2 мянга, нийт зарлагыг 3,007,417.8 мянган төгрөгийг баталсан ба сумын ИТХ-ын 2023.07.25-ний өдрийн 11/03 дугаар тогтоолоор нийт орлогыг 271,885.2 мянга, нийт зардлыг 50,997.1 мянган төгрөгөөр тус тус нэмж тодотгосон байна.

Хүснэгт №15. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	143,491.5	143,491.5	0.0
Засаг даргын Тамгын газар	585,533.1	923,752.1	-338,219.0
Сургууль	174,461.2	174,461.2	0.0
Цэцэрлэг	97,277.1	97,277.1	0.0
Эрүүл мэндийн төв	43,998.4	43,998.4	0.0
Соёлын төв	60,757.1	60,757.1	0.0
Сум хөгжүүлэх сан		82,514.7	-82,514.7
Орон нутгийн хөгжлийн сан		1,481,165.7	-1,481,165.7
Нийт дүн	1,105,518.4	3,007,417.8	-1,901,899.4

Эх сурвалж: Баян-Овоо сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.9.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2022.12.19-ний өдрийн хуралдаанаар 08/01 дугаар тогтоолоор анх 3,007,417.8 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2023.07.25-ний өдрийн 11/03 дугаар тогтоолоор 50,997.1 мянган төгрөгөөр өсгөж 2,956,420.7 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 215,249,8 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 2,607,999.0 мянган төгрөгийг сумын орон нутгийн орлогоос, 1,000.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 68,623.3 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн орлогоос, 326,834.1 мянган төгрөгийг урьд оны төсвийн үлдэгдлээс, 179,000.0 мянган

төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн хандив тусламжийн орлогоос тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл оны эхэнд 214,947.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант онд 2,400,920.6 мянган төгрөгийн татварын болон татварын бус орлогыг төвлөрүүлж аймгийн төсвийн орлогод 300,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлж сумын төсөвт байгууллагын үйл ажиллагааны зардалд 2,273,755.9 мянган төгрөгийн зарцуулсан байна.

Гүйцэтгэлээр сумын төсөвт байгууллагууд орон нутгийн орлогоос 2,273,755.9 мянга, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс 209,739.4 мянга, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 1,000.0 мянга, хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн орлогоос 76,709.3 мянга, орон нутгийн хөгжлийн сангийн орлогоос 202,373.0 мянга нийт 2,763,577.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэн 12,951.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №16. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	ОН
ЗДТГ	993,578.1	985,987.0	7,591.1	99.2	7,356.0
ИТХ	158,191.5	141,943.5	16,248.0	89.7	2,615.2
Соёлын төв	60,757.1	40,393.7	20,363.4	66.5	2,796.3
Сум хөгжүүлэх сан	82,514.7	100.0	82,414.7	0.1	
Сургууль	180,461.2	175,197.1	5,264.1	97.1	13.5
Цэцэрлэг	84,517.9	84,517.9	-	100.0	
ЭМТ	43,998.4	43,828.5	169.9	99.6	169.9
ОНХС	1,352,402.1	1,224,867.8	127,534.3	90.6	
Нийт дүн	2,956,421.0	2,696,835.4	259,585.6	91.2	12,951.0

Эх сурвалж: Баян-Овоо сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,696,835.4 мянган төгрөг буюу 91.2 хувьтай байгаа нь ЗДТГ-ын урсгал зардлыг 7,591.1 мянга, ИТХ-ын урсгал зардлыг 16,248.0 мянга, орон нутгийн хөгжлийн сангийн зардлыг 1,224,867.8 мянга, хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгоогүйтэй холбоотой 82,414.7 мянга, соёлын төвийн урсгал зардлыг 20,363.4 мянга, ЕБС-ийн урсгал зардлыг 5,264.1 мянга, эрүүл мэндийн төвийн урсгал зардлыг 169.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.9.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 10,929.4 мянга, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 23,848.4 мянга нийт 34,777.9 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 30,512.8 мянган төгрөгийг зарцуулж 4,265.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 16. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ИТХ	ЗДТГ	НИЙТ
НИЙТ ОРЛОГО	1,308.2	33,469.7	34,777.9
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,300.0	9,629.4	10,929.4
Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8.2	23,840.2	23,848.4
НИЙТ ЗАРЛАГА	1,300.0	29,212.8	30,512.8
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,300.0	29,212.8	30,512.8
Төсөвт төвлөрүүлсэн	8.2	4,256.9	4,265.1

Эх сурвалж: Баян-Овоо сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

АУДИТЫН ТАЙЛАН

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Овоо сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж ахлах аудитор М.Алтантуяа, Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар үе шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Овоо сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дүгээр сарын 07-ний өдрийн 34 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Баян-Овоо сумын Засаг даргын 1 дүгээр гарын үсгийг Засаг дарга Ж.Хатанбаатар, 2 дугаар гарын үсгийг санхүүгийн албаны дарга Д.Эрдэнэбулган нар зурж байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг

буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 80 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн 2,493,235.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 19,536.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлын төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 13,675.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон *Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг* шалгаж үр дүнг баримтжуулсан.

4.4 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд сумын Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих 2,509,251.9 мянган 11 төсөл арга хэмжээний тендерийг зарлаж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байхад шилэн дансны цахим сайтын худалдан авах ажиллагааны тайлан хэсэгт мэдээлээгүй байна.

4.5 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг хуулийн хэрэгжилтийг Баян-Овоо сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад зөрчил илрээгүй.

4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 58,090.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 75,313.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага, 26,781.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй 1 зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 18-ний өдрийн 84 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна.

Хүснэгт 20 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт
/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	4	75,313.3	4	75,313.3			100.0
Зөвлөмж	1	26,781.3	1	26,781.3			100.0
Төлбөрийн акт	1	58,090.6	1	58,090.6			100.0
Нийт	6	160,185.2	6	160,185.2			100

4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Өвс тэжээл нийлүүлэх гэрээ “Арслант хүлэг” ХХК-тай байгуулсан 50,000.0 мянга, “Пэйс роуд” ХХК-тай 36,400.0 мянга, малын үүлдэр угсаа сайжруулах гэрээг “Гэгээн шавь” ХХК-тай 35,000.0 мянга, иргэн Ч.Бат-Эрдэнэтэй 48,500.0 мянга, номын сангийн тохижилт хийж, тавилга нийлүүлэх гэрээг “Асгамба сүмбэр” ХХК-тай 20,000.0 мянган төгрөгөөр тус тус байгуулж 189,900.0 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн шилжүүлсэн бөгөөд дээрх хөрөнгүүд нийлүүлэгдээгүй байгаа тул дараагийн аудитаар анхаарах шаардлагатай байна.

4.8 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын орон нутгийн нөөц хөрөнгөнд 85,000.0 төгрөгөөр баталж 81,512.7 мянган төгрөгийг зарцуулж 3,487.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

4.9 Аудитын гол асуудал

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баян-овоо сумын Засаг дарга, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 2023 оны хэрэгжилтийг 91.1 гэж дүгнэсэн байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 2,956,421.0 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 2,696,835.4 мянган төгрөгийг зарцуулж 91.2 хувийн биелэлттэй байна.

Тус сум нь 15 нэр төрлийн орлогоор 2,587,999.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 2,373,816.1 мянган төгрөг төвлөрүүлж, нийт орлогыг 92 хувьтай биелүүлж аймгийн төсөвт 300,000 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 28,411.6 мянга, бууны татвар 180.0 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 1,164.5 мянга, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого 3,066.1 мянга, хүү торгуулийн орлого 8,466.5 төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Харин үл хөдлөх хөрөнгийн албан татвар 8,727.6 мянга, газрын төлбөр 20,149.9 мянга, ан агнуурын орлого 134,280.0 мянга, хог хаягдлын үйлчилгээний төлбөр 1,512.0 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмалын албан татвар 6,000.0 мянга, газрын дуудлага худалдааны орлого 7,200.0 мянга, малд ногдуулах албан татвар 70,220.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Баян-Овоо сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 4 байгууллагын санхүүгийн тайлан 4 улсын төсвийн байгууллагын тогтмол зардал нэгтгэгдсэн байна

Төрийн аудитын байгууллагаас Баян-Овоо сумын Засаг даргын харьяа 1 байгууллагыг дүгнэлтэд өгч 3 байгууллагын санхүүгийн тайланг түүвэр аудитад хамруулан санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн байна.

Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн

Байгууллагын нэр	Байгууллагын тоо				Аудитын санал дүгнэлтийн төрөл					
	Хамрагдвал зохиx	Хамрагдсан	Гүйцэтгэсэн		Бүгд	Үүнээс				
			Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан		Зөрчилгүй	Хязгаарла лттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	
ЗДТГ	1	1	1				1			
ИТХурал	1	1			1					
ОНХС	1	1			1					
СХС	1	1			1					
НИЙТ ДҮН	4	4			3	0	1	0		0

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 379,161.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 114,950.0 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж 2,448.5 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт, 214,201.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага, 1 хариуцлага тооцуулах албан шаардлага өгч ажилласан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №18. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт							
			Залруулга		Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн зөрчил										
ИТХурал	1	5,879.7							1	5879.7
ЗДТГ	9	182,162.2			4	2,448.5	4	176,921.3	1	2,792.4
ОНХСан	5	191,120.0	2	114,950.0			2	37,280.0	1	38,890.0
СХС	1	-	1							
СТА зөрчлийн дүн	16	379,161.9	3	114,950.0	4	2,448.5	6	214,201.3	3	47,562.1
СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал										
ЗДТГ	1							1		
Нийцлийн аудитын дүн	1							1		
Нийт дүн	17	379,161.9	3	114,950.0	4	2,448.5	7	214,201.3	3	47,562.1

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэсэн

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй зөрчлийг санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудиттай холбоотой асуудал гэж ангилан үзсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 379161.9 мянган төгрөгийн 16 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 1 зөрчил тус тус илэрсэн байна.

Хүснэгт 19. Төсвийн шууд захирагчийн зөрчлийн дүн /мянган төгрөгөөр/

Д/д	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт.	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	2	3	4	5	6
Засаг даргын Тамгын газар		182,162.2			
1	Төрийн аудитын газраас тогтоосон төлбөрийг актыг сумын Засаг даргаар төлүүлэхээр байхад төсвийн хөрөнгөөс төлсөн байна.	1,400.0	Төлбөрийн акт тогтоосон	ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч	М.Жавзансүрэн Л.Алимаа
2	Бараа материалын тайлангийн зарцуулалтыг анхан шатны баримттай тулган шалгахад 33.9 мянган төгрөгийн 2 боодол няцалсан будаа, 380.0 мянган төгрөгийн 19 ширхэг улаан хивгийг анхан шатны баримтгүй зарлагадсан байна.	413.3	Төлбөрийн акт тогтоосон	ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч	М.Жавзансүрэн Л.Алимаа
3	Байгууллагын нягтлан бодогч албан хаагч М.Ганбаатарын 11 дүгээр сарын цалинг нийгмийн даатгалын мэдээнд 200.1 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.	200.2	Төлбөрийн акт тогтоосон	ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч	М.Жавзансүрэн Л.Алимаа
4	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтыг хэрэгжүүлэлгүй, тайлант онд 435.0 мянган төгрөгийн нэгжний үнийг 29 албан хаагчид олгосон байна.	435.0	Төлбөрийн акт тогтоосон	ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч	М.Жавзансүрэн Л.Алимаа
5	Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор бараа материалыг тоолсон эсэхийг аудитаар нотолж чадаагүй, агуулахын бүртгэлээр тоолсон гэх боловч тооллогын комиссын гишүүдийн гарын үсэг байхгүй байна.	174,921.3	Албан шаардлага өгсөн	ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч	М.Жавзансүрэн Л.Алимаа
6	Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн газрын судалгаатай санхүүгийн тайлан дахь газартай тулган шалгахад сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/101 дүгээр захирамжаар олгосон 1537 м2 талбай бүхий газрыг санхүүгийн тайланд тусгаагүй байна.	-	Албан шаардлага өгсөн	ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч	М.Жавзансүрэн Л.Алимаа
7	Байгууллагын нярвын бэлтгэсэн бараа материалын тайлангууд ерөнхий дэвтрийн дүнгээс зөрүүтэй, урсгал засварын бараа материалын тайланг гаргаагүй байна.	-	Албан шаардлага өгсөн	ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч	М.Жавзансүрэн Л.Алимаа
8	Баян-Овоо сумын Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн Б/10 дугаар захирамжаар Өвөрмонголын өөртөө засах оронд туршлага судлах зардалд олгосон 2,000.0 мянган төгрөгийн анхан шатны баримт байхгүй байна.	2,000.0	Албан шаардлага өгсөн	ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч	М.Жавзансүрэн Л.Алимаа
9	Байгууллагын өмч хамгаалах зөвлөл автомашины сэлбэгийг олгох талаар хэлэлцээгүй, байгууллагын дарга хөрөнгө захиран зарцуулах шийдвэрийг гаргаагүй, автомашины хувийн хэргийг хөтлөөгүй байна.	2,792.4	Албан шаардлага өгсөн	ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч	М.Жавзансүрэн Л.Алимаа

Баян-Овоо сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

10	Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 32,092.1 мянган төгрөгийн зарлагын 4 гүйлгээ, 130,827.7 мянган төгрөгийн хөрөнгө захиран зарцуулах 21 тушаал, шийдвэр, байгууллагын даргын тайланд онд байгуулсан 15 гэрээг байршуулаагүй орхигдуулсан байгаа бөгөөд өмнөх жилийн зөрчлийг давтан гаргасан байна.	-	Хариуцлага тооцох албан шаардлага өгсөн	ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч	М.Жавзансүрэн Л.Алимаа
Иргэдийн төлөөлөгчийн хурал		7,329.7			
1	Тайлант онд "Сити сейф" ХХК-аас 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдөр авсан 1,450.0 мянган төгрөгийн нягтруулсан шүүгээг машин тоног төхөөрөмж дансанд бүртгэсэн байгаа нь Үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй тул санхүүгийн тайланд тавилга, аж ажуйн эд хогшил дансанд залруулсан.	1,450.0	Санхүүгийн тайланд залруулсан	Нарийн бичгийн дарга Нягтлан бодогч	Д.Батбаатар Л.Алимаа
2	Байгууллагын төсвийн захирагч батлагдсан төсвөөс 5,879.7 мянган төгрөгийн хөрөнгө захиран зарцуулахдаа хөрөнгө зарцуулах тушаалыг тухай бүр гаргаж ажиллаагүй байна.	5,879.7	Зөвлөмж өгсөн	Нарийн бичгийн дарга Нягтлан бодогч	Д.Батбаатар Л.Алимаа
Орон нутгийн хөгжлийн сан		189,670.0			
1	Малын үүлдэр угсаа сайжруулах гэрээг "Гэгээн шавь" ХХК-тай 35,000.0 мянга, иргэн Ч.Бат-Эрдэнэтэй 48,500.0 мянга, номын сангийн тохижилт хийж, тавилга нийлүүлэх гэрээг "Асгамба сүмбэр" ХХК-тай 20,000.0 мянган төгрөгөөр байгуулж санхүүжилтийг бүрэн шилжүүлсэн, бохирын машин нийлүүлэх гэрээг "Ган утас мөнх" ХХК-тай 79,860.0 мянган төгрөгөөр гэрээ байгуулж 10,000.0 мянган төгрөгийг шилжүүлж дээрх хөрөнгүүд нийлүүлэгдээгүй байхад санхүүгийн тайланд 113,500.0 мянган төгрөгийн авлагыг тусгаагүй байна.	113,500.0	Санхүүгийн тайланд залруулсан	Засаг дарга Нягтлан бодогч	Г.Орхонтуул Э.Мөнх-Эрдэнэ
2	Иргэн Д.Гансүхтэй "Ногоон зурвасын дагуу хайс, хүлэмжийн тавиур хийх ажлын гэрээ"-г 17,280,000 төгрөгөөр байгуулж 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдөр хийж дуусгахаар санхүүжилтийг бүрэн олгосон байхад ажил бүрэн хийгдээгүй байна.	17,280.0	Албан шаардлага өгсөн	Засаг дарга Нягтлан бодогч	Г.Орхонтуул Э.Мөнх-Эрдэнэ
3	ОНХС-ийн хөрөнгөөр Баян-Овоо сумын Мандал хайрхан 1 дүгээр багт 2022 онд 20,000,000 төгрөгөөр хийгдсэн худгийн насос суурилуулах ажлыг бүрэн хийж дуусаагүйгээс сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 39 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг одоо болтол уг ажлыг хүлээн аваагүй байна.	20,000.0	Албан шаардлага өгсөн	Засаг дарга Нягтлан бодогч	Г.Орхонтуул Э.Мөнх-Эрдэнэ
4	"Оджи од" ХХК-иас авах 5,000,000 төгрөг, малжуулахын авлага 33,890,000 төгрөг нийт 38,890,000 авлагыг барагдуулаагүй байна.	38,890.0	Зөвлөмж өгсөн	Засаг дарга Нягтлан бодогч	Г.Орхонтуул Э.Мөнх-Эрдэнэ
Нийт дүн		379,161.9			

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 2,757,341.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, алдаа зөрчил давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг хүргүүлээ.

5.1. Албан шаардлага

1. Үл хөдлөх хөрөнгийн албан татвар 8,727.6 мянга, газрын төлбөр 20,149.9 мянга, ан агнуурын орлого 134,280.0 мянга, хог хаягдлын үйлчилгээний төлбөр 1,512.0 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмалын албан татвар 6,000.0 мянга, газрын дуудлага худалдааны орлого 7,200.0 мянга, малд ногдуулах албан татвар 70,220.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална” 5.1.1 дэх “Жинхэнэ хэрэгжилтийн”, Үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сумын төсөвт төвлөрүүлэх орлогыг үндэслэлтэй төлөвлөж байх, төсөвт бүрэн төвлөрүүлэх албан шаардлагыг хүргүүлэв.

2. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд сумын Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих 2,509,251.9 мянган 11 төсөл арга хэмжээний тендерийг зарлаж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байхад шилэн дансны цахим сайтын худалдан авах ажиллагааны тайлан хэсэгт мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдээлж байх албан шаардлагыг хүргүүлэв.

5.1. Зөвлөмж

1.Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайланг ирүүлэхдээ төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр 54.5 дэх хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр ирүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна”, 54.5.4 дэх “Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Сумын ТТЗ-ийн санхүүгийн тайланг ирүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 -д заасан бүрэлдэхүүн хэсгээр ирүүлэх зөвлөмжийг хүргүүлж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Баян-Овоо сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг ирүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр тайланг ирүүлээгүй	1	0					1	0
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар 8,727.6 мянга, газрын төлбөр 20,149.9 мянга, ан агнуурын орлого 134,280.0 мянга, хог хаягдлын үйлчилгээний төлбөр 1,512.0 мянга, түгээмэл тархцтай ашигт малтмалын албан татвар 6,000.0 мянга, газрын дуудлага худалдааны орлого 7,200.0 мянга, мэлд ногдуулах албан татвар 70,220.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна	1	248,089.5			1	248,089.5		
Дүн	2	248,089.5			1	248,089.5	1	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил								
Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд сумын Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих 2,509,251.9 мянган 11 төсөл арга хэмжээний тендерийг зарлаж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байхад шилэн дансны цахим сайтын худалдан авах ажиллагааны тайлан хэсэгт мэдээлээгүй байна.	1	2,509,251.9			1	2,509,251.9		
	1	2,509,251.9			1	2,509,251.9		